



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 4/141

Сүхбаатар сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Харилцаа, холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Барилга, хот байгуулалтын Сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд заагдсан Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх зохион байгуулах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

А.Эрдэнэгэрэл

- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Ч.Доржмягмар

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Гүндэгмаа

-Статистикийн хэлтсийн дарга

З.Түвшинтөгс

-Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Хангал

-Аймгийн ерөнхий архитектор.

Н.Эрдэнэцогт

-Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга

О.Баатарцогт

-Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГазрын захирал

М.Батболд

-Урсгал Ус ОНӨААТҮГазрын ерөнхий инженер


Ц.Мөнхдорж

-Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГазрын ерөнхий инженер

М.Болор-Эрдэнэ	-Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ний Сүхбаатар салбарын ашиглал засварын мастер
Д.Агиймаа	-Мэдээлэл холбоо сүлжээ ХХК –ний ерөнхий инженер
Н.Пүрэвсүрэн	-Сэлэнгэ АЗЗА ТӨХК –ний ерөнхий инженер

2. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, үйл ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, тайлан, төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /А.Эрдэнэгэрэл/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ